

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2023 оны 02 дугаар сар/**


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 18 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM_{2.5}, PM₁₀ тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлдог.

Улаанбаатар хотын 2023 оны хүйтний улирал 02 дугаар сарын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2022 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад PM₁₀ тоосонцор 12 мкг/м³-ээр буюу 9 %-иар, PM_{2.5} тоосонцор 8 мкг/м³-ээр буюу 10 %-иар, хүхэрлэг хий (SO₂) нь 20 мкг/м³-ээр буюу 15 %-иар бага, харин азотын давхар исэл (NO₂) нь 5 мкг/м³-ээр буюу 9 %-иар их байна.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2022 оны 02 дугаар сар	2023 оны 02 дугаар сар
PM ₁₀ тоосонцор	100	128	116
PM _{2.5} тоосонцор	50	78	70
Азотын давхар исэл, NO ₂	50	55	60
Хүхэрлэг хий, SO ₂	50	131	111

Улаанбаатар хотын сүүлийн 6 жил буюу 2018-2023 оны 02 дугаар сарын хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт дэлгэрэнгүй үзүүлээ.


PM₁₀ тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын PM₁₀ тоосонцрын сарын дундаж агууламж, 2018-2023 он

Агаар дахь PM10 тоосонцрын 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламж 116 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 9 %-иар бага. Харин агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1.1 дахин их байна. (Зураг 1).


PM2.5 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2018-2023 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцор 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламж 70 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 10 %-иар бага. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1.4 дахин их байна. (Зураг 2).


Азотын давхар исэл (NO₂)



Зураг 3. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2018-2023 он

Азотын давхар ислийн 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламж 60 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 9%-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1.2 дахин их байна. (Зураг 3).

Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2018-2023 он

Агаар дахь хүхэрлэг хийн 2023 оны 02 дугаар сарын дундаж агууламж 111 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 02 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 15%-иар бага. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 2.2 дахин их байна. (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС